



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 0000-2025/30

Сүхбаатар сум

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны  
санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн  
Хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан  
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 07 дүгээр сарын 30-ны өдрийн СХШ-2025/03/ТШЗ дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулан зөвлөх зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т.Мөнхзул ахлан, дотоод аудитор Д.Ванчигмаа 2025 оны 08 дүгээр сарын 25-ний өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтаар Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны 2024 он, 2025 оны 2-р улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны улсын бүртгэлийн 9055282 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131855001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100131855408 дугаартай дансуудыг ашиглаж байна.

1.5 Тус газрын төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албан дарга Д.Эрдэнэбулган 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Жавхланзаяа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 06 сарын 19 өдрийн А/12 дугаар тушаалын мөрдөж, сумын захирамж 16 бүтэц

4325001183

орон 16 батлагдсанаас одоогийн байдлаар байгууллага нь 13 оронтой ажилласан байна.

1.7 Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сум, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж, иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх зарчмыг бүх шатны төрийн байгууллагуудад хэвшүүлэн ажиллаж байна. Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан, Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

### Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

#### 2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1. Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна

#### 2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны 2024 онд 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр 778,381.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 99.7 хувь буюу 776,155.7 мянган төгрөгийг зарцуулж, 0.3 хувь буюу 2,226.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 263.5 мянган төгрөгийн, хангамж бараа материалын зардлаас 2,226.1 мянган төгрөгийг үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2024	2024	хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
		Батлагдсан Төсөв	гүйцэтгэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	778,381.8	776,155.7	2,226.1	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	778,381.8	766,735.7	11,646.1	98.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,277.4	332,013.9	263.5	99.9
210101	Үндсэн цалин	176,472.2	178,874.9	2,402.7	101.4

210102	Нэмэгдэл	155,805.2	126,012.4	29,792.8	80.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	9,233.5	9,233.5	
210104	Урамшуулал	0.00	17,893.0	7,893.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,534.7	43,760.8	2,226.1	105.4
210201	Тэтгэврийн даатгал	28,963.6	31,189.7	2,226.1	107.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,142.8	3,142.8	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,571.4	1,571.4	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,571.4	1,571.4	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,285.5	6,285.5	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,208.0	141,208.0	0.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,200.0	5,200.0	0.0	100.0
210302	Түлш, халаалт	115,368.0	115,368.0	0.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	20,640.0	20,640.0	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	27,759.7	25,533.6	2,226.1	92.0
210401	Бичиг хэрэг	3,968.3	4,768.2	799.9	120.2
210402	Тээвэр, шатахуун	17,182.2	13,640.6	3,541.6	79.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400.0	2,694.0	294.0	112.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,209.2	4,430.8	221.6	105.3
2105	Нормативт зардал	1,000.0	0.00	1,000.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000.0	0.00	1,000.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,551.4	31,551.4	0.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,873.7	1,900.0	973.7	66.1
210604	Урсгал засвар	28,677.7	29,651.4	973.7	103.4
2107	Томилолт, зочны зардал	4,177.4	3,977.5	199.9	95.2
210702	Дотоод албан томилолт	4,177.4	3,977.5	199.9	95.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,353.2	58,685.3	667.9	98.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,300.0	58,300.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	250.0	0.00	250.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	503.2	360.3	142.9	71.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150.0	25.0	125.0	16.7
210807	Газрын төлбөр	150.0	0.00	150.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,100.0	130,005.2	94.8	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,100.0	125,005.2	94.8	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000.0	5,000.0	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,420.0	9,420.0	0.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,420.0	9,420.0	0.0	100.0

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,920.0	7,920.0	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500.0	1,500.0	0.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	778,381.8	776,155.7	2,226.1	99.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	778,381.8	776,155.7	2,226.1	99.7
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	25.00	25.00	0.0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	12.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.00	12.00	0.0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.00	5.00	1.0	83.3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.0	0.0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00	0.0	100.0

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны 2024 онд 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр 542,669.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 77.0 хувь буюу 419,835.1 мянган төгрөгийг зарцуулж, 23.0 хувь буюу 122,834.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 7,270.3 мянган төгрөгийн, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,079.6 мянган төгрөгийг, Түлш, халаалт 7,210.5 мянган төгрөгийг, хангамж бараа материалын зардлаас 1,998.2 мянган төгрөгийг, Цэвэр, бохир ус 92,930.0 мянган төгрөгийн, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,612.1 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай

Код	Үзүүлэлт	2025оны 2-р улирлын байдлаараа	2025оны 2-р улирлын байдлаараа	хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
		Батлагдсан Төсөв	гүйцэтгэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	542,669.8	419,835.1	122,834.7	77
	УРСГАЛ ЗАРДАЛ	542,669.8	419,835.1	122,834.7	77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,424.8	418,335.1	113,089.7	78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,183.0	187,912.7	7,270.3	96
210101	Үндсэн цалин	89,568.0	89,477.5	90.5	100
210102	Нэмэгдэл	93,672.60	93,146.1	526.5	99
210104	Урамшуулал	11,942.0	5,288.4	6,653.6	44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,397.8	23,437.7	960.1	96
210201	Тэтгэврийн даатгал	16,590.6	15,629.9	960.7	94

210202	Тэтгэмжийн даатгал	1,951.8	1,951.8	0.0	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,561.2	1,561.2	0.0	100
210204	Ажилгүйдлийн даатгал	390.6	390.6		100
210205	Эрүүл мэндийн даатгал	3,903.60	3,903.6	0.0	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,225.0	105,145.4	5,079.6	95
210301	Гэрэл, цахилгаан	27,800.0	29,930.9	2,130.9	108
210302	Түлш, халаалт	72,105.0	64,894.5	7,210.5	90
210303	Цэвэр, бохир ус	103,250.0	10,320.0	92,930.0	10
2104	Хангамж, бараа материалын зардал	13,249.8	11,251.6	1,998.2	85
210401	Бичиг хэрэг	2,000.0	1,198.5	801.5	60
210402	Тээвэр, шатахуун	7,500.0	7,500.0	0.0	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,399.8	1,233.6	166.2	88
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350.0		350.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000.0	1,319.5	680.5	66
2105	Нормативт зардал	800.0	0.00	800.0	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800.0	0.00	800.0	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,368.8	26,752.1	616.7	98
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000.0	9,354.9	645.1	94
210602	Тавилга	7,025.0	7,397.2	-372.2	105
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	343.8		343.8	0
210604	Урсгал засвар	10,000.0	10,000.0	0.0	100
2107	Томиллолт, зочны зардал	2,500.0	1,740.0	760.0	70
210702	Дотоод албан томиллолт	2,500.0	1,740.0	760.0	70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,050.0	437.9	1,612.1	21
210803	Даатгалын үйлчилгээ	600.0	35.0	565.0	6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600.0	302.9	297.1	50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100.0	100.0	0.0	100
210807	Газрын төлбөр	250.0	0.00	250.0	0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500.0		500.0	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,650.4	61,658.6	93,991.8	40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153,150.4	61,658.6	91,491.8	40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500.0	1,500.0	1,000.0	60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,245.0	1,500.0	9,745.0	13
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,245.0	9,420.0	1,825.0	84
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,745.0	7,920.0	825.0	91

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500.0	1,500.0	1,000.0	60
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	542,669.8	452,938.8	89,731.0	83
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	539,669.8	452,938.8	86,731.0	84
	Төсөвт Байгууллагын үйл ажиллагаанаас	3,000.00		3,000.0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		33,103.6	-33,103.6	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	25.00	25.00	0.0	100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.0	100
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.0	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	12.00	0.0	100
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	0.0	100
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.0	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.00	12.00	0.0	100
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.00	5.00	1.0	83
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.0	0.0	100
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00	0.0	100

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна.

**2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд:** 2024 онд 100131855408 төрийн сангийн 63,000.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Бараа үйлчилгээний бусад зардалд 63,000 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2025 оны 2-рулирлын байдлаараа 175,500.0 мянган төгрөг төвлөрүүлсэн, бөгөөд бараа үйлчилгээний бусад зардалд 175,500.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

### **2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал**

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба даргын тушаал 2025 оны 01-р дүгээр сарын 02 өдөр Б/01 тушаалаар албан хаагчдын цалин шинэчлэн тогтоосон байна.

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба 2024 он 2025 оны 2-р улирлын байдлаараа ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэр тулган баталгаажуулахад зөрүүгүй байна.

2024 он, 2025 оны 2 улирлын байдлаар НДШ, ХАОАТ-ийн өр, авлагагүй байна. Үүнд. Бугант тосгоны Захирагчийн алба нь сумын ЗДТГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоог хэтрүүлсэн буюу орон тоонд батлагдаагүй цалин урамшууллын зардалд зарцуулсныг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг 2025 оны 1 сард хэрэгжүүлэн ажилласан байна

## **2.6. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт**

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба 2024-2025 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг хүртэл хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авалт хийдээгүй байна

## **2.7. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал**

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны даргын 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоог хэтрүүлсэн буюу орон тоонд батлагдаагүй томилон ажиллуулж, цалин урамшууллын зардалд 25,247.8 мянган төгрөгийг зарцуулсанд . Баталсан орон тооны хязгаарыг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлсныг 90% биелэлт байна

## **2.8 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт**

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба 2024 оны 4,572,792.5 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн үлдэгдэлтэй болж Үүнээс машин тоног төхөөрөмж 101,807.6 мянган төгрөгийн, тээврийн хэрэгсэл 6,692.8 мянган төгрөгийн, Зам гүүрийн байгууламж 500,000.0 мянган төгрөгийн Програм хангамж 1,250.0 мянган төгрөгийн ахуйн эд хогшил 21,082.0 мянган төгрөгийн тус тус нэмэгдсэн байна. 2025 оны 2-р улирлын Машин тоног төхөөрөмж 9,345.9 мянган төгрөгөөр Тавилга эд хогшил 7,397.2 мянган төгрөгөөр нийт 16,743.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн буюу Машин тоног төхөөрөмж 14,943.4 мянган төгрөгийн Тавилга эд хогшил 16,025.7 мянган төгрөгийн хөрөнгө нийт 30,969.1 мянган төгрөгийн акталсан байна

2025 оны 2-р улирлын байдлаар 4,558,575.5 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн хөрөнгийн үлдэгдэлтэй Үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна. Үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллогыг хагас бүтэн жилээр хийж эд хариуцагчийн картыг хөтөлж хэвшсэн байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг явцад ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалт гаргаж өмч хамгаалах зөвлөлд шилжүүлэн , акталж устгах, шилжүүлэх зэргээр холбогдох дээд газрын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж , данс бүртгэлд тусгасан байна 2024-2025 онд Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгө шинээр авч байгаа хөрөнгөд

бүрэн бүтэн байдал чанарын шаардлага хангасан дээр 5 удаа хуралдсан байна. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглах боломжгүй хөрөнгийн талаар 5 удаа хуралдаж, хугацаа дууссан хөрөнгийг буюу элэгдлээрээ өртөг нөхсөн хөрөнгийг актлах саналыг хурлын шийдвэр гаргасныг байгууллагын удирдлагууд танилцуулж ажилласан байна

## **2.9. Дотоод хяналтын үр нөлөө**

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба 2024 онд хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төрийн сантай холбоотой ажил гүйлгээний чиглэлээр боловч дотоод хяналтын үр дүнд дунд байна

### **2.10 Санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлийг заавар аргачлалын дагуу бүрэн үнэн зөв хөтөлсөн эсэх**

1.Төсвийн зохицуулалт хийх дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 9,587.1 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан

- 2024 онд бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 4,327.0 мянган төгрөгийг сэлбэг хэрэгсэл, хэвлэл, засварын материал, хулдаасан хэвлэл, хоолны зардал байр зүйн зургийн зардал, цэвэрлэгээний материал г.м/ зардлууд
- 2025 онд бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 5,260.1 мянган төгрөгийг бөхийн шагналд, шатахуун, машины засвар, шагнал г.м/ зардлуудыг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.4 дэх "Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", тавдугаар хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангиллын тайлбар"-ыг тус тус зөрчсөн байна.

2. Худалдан авалтын цахим төлбөрийн баримтаар баталгаажуагүй, бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг бөөн дүнгээр бүртгэсэн нийт 22,832.1 мянган төгрөгийг зөрчсөн байна

- 2024 онд 16,232.0 мянган төгрөг
- 2025 онд 6,600.0 мянган төгрөг

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын

тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

3. 2024 онд 4,325.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэсэн / Тушаал, зардлын төсөв тооцоо, тайлангууд, гэрээ дүгнэсэн акт байхгүй /

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төсвийн тухай хуулийн 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

#### **Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал**

2024 он, 2025 оны 3-р улирлын төсөв, санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэргийг тулган шалгахад холбогдох хууль, журам, стандартын дагуу хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршоор байна. Үүнд

Илрүүлэлт 1 Төсвийн зохицуулалт хийх дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 9,587.1 мянган төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан

- 2024 онд бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 4,327.0 мянган төгрөгийг сэлбэг хэрэгсэл, хэвлэл, засварын материал, хулдаасан хэвлэл, хоолны зардал байр зүйн зургийн зардал, цэвэрлэгээний материал г.м/ зардлууд
- 2025 онд бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 5,260.1 мянган төгрөгийг бөхийн шагналд, шатахуун, машины засвар, шагнал г.м/ зардлуудыг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.4 дэх "Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", тавдугаар хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангиллын тайлбар"-ыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах байх "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" дагуу ашиглаж байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 2** 2.Худалдан авалтын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг бөөн дүнгээр бүртгэсэн нийт 22,832.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ

- 2024онд 16,232.1 мянган төгрөг
- 2025онд 6,600.0 мянган төгрөг

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна."Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6.5 дахь " Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авалт хийх тухай бүрд бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо ширхгээр хэмжээ орлого авч, цахим баримтаар баталгаажуулж, зарцуулалтаараа зарлагадаж байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 3.** 2024 онд 4,325.0 мянган төгрөг анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэсэн / Тушаал, зардлын төсөв тооцоо, тайлангууд, гэрээ дүгнэсэн акт байхгүй /

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"Төсвийн тухай хуулийн 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хүчин төгөлдөр бус, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулж ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:**

##### **4.1 Дүгнэлт:**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл

ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

#### 4.2 Шийдвэрлэлт:

Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны даргын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **36,744.2** мянган төгрөгийн **3** зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 32,419.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, давтан гаргахгүй 4,325.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

#### Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн албаны дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

#### ТАЙЛАН БЭЛТГЭСЭН :

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДОТООД АУДИТОР  
*Д.Ванчигмаа*  
Д.ВАНЧИГМАА

#### ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  
*Мөнхзул*  
МӨНХЗУЛ



#### ТАНИЛЦСАН :

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ  
СУМ БУГАНТ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ  
*Д.Эрдэнэбулган*  
Д.ЭРДЭНЭБУЛГАН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
*Б.Жавхланзаяа*  
Б.ЖАВХЛАНЗАЯА

